



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТАГТ ЭРХ ШИЛЖИН ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 58.6 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ.

АУДИТЫН КОД: ЗАА-2025/06-12-ШТА-НА



Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330, Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
Аудитор Н.Цогтсайхан
Утас: 99125745 Цахим хаяг: tsogtsaikhann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
www.open.audit.mn хаягаас үзнэ үү

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	2
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4

ЗОРИЛТ 1. УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАЖ, ОРОН НУТАГТ ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ШИНЭЭР ЭХЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 58.6 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БАЙНА..... 5-10

- 1.1 Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээнүүдийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.
- 1.2 Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад баталсан байна.
- 1.3 Зураг төсөлгүй, зураг төсөлд магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталжээ.
- 1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй төсөл арга хэмжээ баталсан байна.

ЗОРИЛТ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ГАРГАСАН ГОМДОЛТОЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА..... 11-20

- 2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлэх үйл ажиллагаа хугацаа хоцорсон байна.
- 2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулах шаардлагатай байна.
- 2.3 Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулаагүй, шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна.

ЗОРИЛТ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЭН ХҮЛЭЭН АВААГҮЙ БАЙНА.....21-29

- 3.1 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлжээ.
- 3.2 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй, гэрээний хугацааг сунгасан байна.
- 3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй байхад хүлээн авсан байна.
- 3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгасан байна.

ДҮГНЭЛТ.....

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ.....

ЗӨВЛӨМЖ:.....

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР.....

30

31

32

33

34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХБТХО	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Эрх шилжсэн ТАХ	
2	Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцоо хийгдээгүй ТАХ	
3	Сүүлийн 2 жилд хийсэн магадлалын дүгнэлтгүй ТАХ	
4	Батлагдсан төсөв магадлалын дүнгээс зөрүүтэй ТАХ	
5	Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо, жагсаалт-ТЕЗ-аар	
6	Үнэлгээний хорооны зохион байгуулсан ХАА-ны тоо	
7	ТАХ-ний ХАА-г зохион байгуулсан тоо, төсөвт өртөг, тендерийн хэмнэлт	
8	Хууль, журамд нийцүүлэн үнэлээгүй ТАХ-ний тоо	
9	Барьцаа хөрөнгийн дансанд үлдэгдэлтэй ТАХ	
10	Батлагдсан төсөвт зохицуулалт хийсэн ТАХ	
11	Нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдээлэл	

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу хийж гүйцэтгэсэн.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгөн, зөвлөмж боловсруулж дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • <i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;</i> • <i>Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;</i> • <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх;</i>
Аудитын хамарсан хүрээ	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн ТЕЗ, аймгийн ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газар, ЗДТГ-ын дэргэдэх ХБТХО-ын хэлтэс, тэдгээрийн холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүд, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг гүйцэтгэгч компаниуд, ашиглагч байгууллагуудыг хамруулан, төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд аудитыг хийж гүйцэтгэсэн.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300,400,3000-3100,4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан.

**Аудитын багийн
бүрэлдэхүүн,
хугацаа****Хүндрэл бэрхшээл**

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Б.Жалбаа, аудитор Н.Цогтсайхан нар 2025 оны 03 дугаар сарын 06-аас эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 18-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэх хугацаанд санхүүгийн тайлангийн аудитыг зэрэгцүүлэн гүйцэтгэсэн нь цаг хугацаандаа амжихгүй байх эрсдэлийг үүсгэж байлаа.

Аудитын ерөнхий мэдээлэл

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний жагсаалтад Завхан аймагт хэрэгжүүлэхээр 258,017.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 төсөл арга хэмжээг баталсны 39 нь шинэ хэрэгжих төсөл арга хэмжээ байна.

Орон нутагт 159,910.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл арга хэмжээг эрх шилжүүлсэн байна. Үүнээс 30,156.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжсэн хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 1. Эрх шилжсэн төсөл арга хэмжээ /шинэ/
сая.төг

д/д	Эрх шилжүүлсэн шийдвэр	Огноо	ТАХ тоо	Төсөвт өртөг
1	Засгийн газрын тогтоол	2023.11.22 №409	27	128,953.5
2	Соёлын сайдын тушаал	2024.02.06 №А/30	1	300.0
3	Эрчим хүчний сайдын тушаал	2024.01.31 №А/49	1	500.0
ДҮН			29	129,753.5

Зорилт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, орон нутагт эрх шилжүүлсэн шинээр эхлэх төсөл арга хэмжээний 58.6 хувь нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээнүүдийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна. /1.1/

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдан орон нутагт Засгийн газрын тогтоолоор эрх шилжсэн шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүд нь МУ-ын 2021-2025 хөрөнгө оруулалтын хөтөлбөр /УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол/, улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө /УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоол/-тэй уялдсан байдлыг тулган шалгахад дараах байдалтай байна.

Завхан аймагт 2024 онд эрх шилжин шинээр хэрэгжих 27 төсөл арга хэмжээний 44.8 хувь нь дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй байна. Үүнд: Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, хүний хөгжлийн ордон, соёлын

төвийн барилга, ногоон байгууламж бүхий орчны тохижилт, соёлын төвийн барилга, боловсролын салбарын тоног төхөөрөмж зэрэг байна.

Аймгийн 2021-2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй /аймгийн ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоол/ тулган үзэхэд шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний 5 буюу 27.8 хувь нь тусгагдаагүй, харин аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд бүрэн тусгагдсан байна.

Энэ нь жилийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэдэггүй, бодлогын баримт бичгийн уялдаа холбоог харгалздаггүйг харуулж байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан ажлууд нь Алсын хараа-2050 урт хугацааны бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдсан хэдий ч хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8-д “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх”, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-д “нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээлэл, аргачлал нь нэгдмэл, уялдаатай байж, бодлогыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг; 5.2.17-д “төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим” гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын болон орон нутгийн төсвийг төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулахыг” гэсэн заалтуудтай зөрчилдөж байна.

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад баталсан байна./1.2/

Аймгийн засаг дарга улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 56 шинэ төсөл арга хэмжээг тусгуулахаар Сангийн яаманд санал хүргүүлсэн байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Завхан аймагт шинээр хэрэгжих 39 төсөл арга хэмжээг тусгажээ.

Аймгийн засаг даргаас хүргүүлсэн хөрөнгө оруулалтын төслийг улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалттай харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан 39 шинэ төсөл арга хэмжээний 22 нь аймгийн Засаг даргын хүргүүлсэн төсвийн төсөлд тусгагдсан ажил байна.

Орон нутагт эрх шилжсэн, шинээр эхлэх 29 төсөл арга хэмжээний 11 буюу 37.9 хувь нь төсвийн төсөлд тусгагдаагүй, ТЕЗ-ын шийдвэрээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан ажлууд байна. Үүнд:

- ✓ Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал /Завхан, Завханмандал сум/

- ✓ Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Отгон сум/
- ✓ Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Дөрвөлжин сум/
- ✓ Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай сум/
- ✓ Сумын төвийн цэвэр усны шугам сүлжээ /Завхан, Тосонцэнгэл сум/
- ✓ Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Завхан/
- ✓ Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Завхан/
- ✓ Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Завхан/
- ✓ Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Завхан/

Дараах ТАХ нь ТЕЗ-тай байгуулсан гэрээний хүрээнд орон нутагт эрх шилжин хийгдсэн байна.

- ✓ Эрчим хүчний тусгай зориулалтын тоног төхөөрөмж, ухаалаг тоолуур худалдан авах /Завхан, Улиастай, Яруу, Цагаанхайрхан сумд/Эрчим хүчний сайдын багцаас задарсан/
- ✓ Мичид кино театрын тоног төхөөрөмж /Соёлын сайдын багцаас задарсан/

Сангийн яаманд хүргүүлсэн төсвийн төсөлд тусгагдсан, орон нутагт эрх шилжин шинээр хэрэгжих төсөл арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцоог хийсэн байдалд хяналтыг хэрэгжүүлэхэд 10 буюу 34.5 хувь нь зөрчилтэй байна. Үүнд:

Хүснэгт 2. Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцоо хийгдээгүй ТАХ /шинэ/

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Тайлбар
1	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Отгон сум/	2024 оны төсвийн төсөлд санал дүгнэлт гаргах аудитаар илэрсэн зөрчил /ҮАГ/
2	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Эрдэнэхайрхан сум/	
3	Хөгжим бүжгийн коллежийн дотуур байрны барилга, 150 ор /Завхан, Улиастай сум/	
4	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Дөрвөлжин сум/	
5	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Завхан/	
6	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай сум/	
7	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Завхан, Баянтэс сум/	https://pimis.publicinvestment.gov.mn/ буюу төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр төсөл арга хэмжээг үнэлэх ажлыг гүйцэтгэсэн байна. Эдгээр төсөл арга хэмжээнүүдэд эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийгдээгүй гэсэн үндэслэлээр нөөцөд бүртгэсэн байхад хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан байна.
8	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Завхан, Сантмаргаз сум/	
9	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Завхан, Тэлмэн сум/	
10	Соёлын төвийн барилга, 230 суудал /Завхан, Ургамал сум/	

Төсөл арга хэмжээг аргачлалын дагуу үнэлсэн байдлыг үзэхэд аймгийн засаг дарга төсвийн төсөлд тусгасан төсөл арга хэмжээг холбогдох журмын дагуу үнэлсэн байна. Харин салбар яамд буюу ТЕЗ-чид болон Сангийн яам зарим төсөл арга

хэмжээг цахим системээр үнэлгээ хийсэн эсэх нь тодорхойгүй, цахим системийн 2-р шатны үнэлгээ хийсэн төсөл арга хэмжээний жагсаалтад бүртгэлгүй байхад улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна. Үүнд:

- ✓ Богд, Чигэстэйн голын төмөр бетон гүүр, 290.03 у/м /Завхан, Улиастай сум/
- ✓ Улиастай сумын Чигэстэй багийн явган болон дугуйн зам, 3.9 км /Завхан, Улиастай сум/
- ✓ Хүний хөгжлийн ордны барилга /Завхан, Тосонцэнгэл сум/
- ✓ Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Сонгино сум/
- ✓ Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Баянхайрхан сум/

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна” гэсэн заалттай нийцээгүй байна.

Холбогдох журмын дагуу үнэлж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан төсөл арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийхэд 0-55 хувьтай үнэлэгдсэн байна. Энэ нь тухайн төсөл арга хэмжээнүүд төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан гэж үзэхэд хангалтгүй үнэлгээ бөгөөд Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-д хэдэн хувиас дээш үнэлэгдсэн төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах талаар тодорхой заагаагүйтэй холбоотой байна. Иймд дээрх журамд үнэлгээний тодорхой хязгаар тогтоож өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Зураг төсөлгүй, зураг төсөлд магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталжээ /1.3/

Орон нутагт шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийн холбогдох хуульд заасан төлөвлөлтийн шаардлагыг хангасан эсэхийг тулган шалгахад зураг төсөл боловсруулаагүй, зураг төсөлд магадлал хийгдээгүй зарим төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

Эдгээр төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын төсвийн төсөлд тусгагдсан болон ТЕЗ-ийн санаачилгаар хэрэгжүүлсэн байдлаар авч үзвэл:

Хүснэгт 3. Сүүлийн 2 жилд хийсэн магадлалын дүгнэлтгүй ТАХ /шинэ/

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Тайлбар
ТЕЗ-ийн санаачилгаар хэрэгжүүлсэн ТАХ		
1	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт тохижилт	Зураг төслийг тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэж байх хугацаанд /2024.11.12/ боловсруулан, ажил дууссаны дараа магадлалын дүгнэлт /2024.11.28/ хийгдсэн байна.

2	Хүүхдийн цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Отгон/	Зураг төсөлд магадлалын дүгнэлт 2024.05.14-д хийгдсэн байна.
3	Соёлын төвийн барилга, 200 суудалтай /Завхан, Дөрвөлжин/	Зураг төсөлд магадлалын дүгнэлт 2024.08.26-д хийгдсэн байна.
4	Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал /Завхан, Завханмандал	Зураг төсөлд магадлалын дүгнэлт 2023.08.25-д хийгдсэн нь аймгийн Засаг дарга Сангийн яаманд төсвийн төсөл хүргүүлснээс хойших хугацаа байна.
5	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай/	Уг төсөл арга хэмжээ нь барилгын ажлын зураг төсөв, гадна шугам сүлжээний угсралтын ажлын зураг төсөв гэсэн 2 төсөвтэй байна. Барилгын ажлын төсөлд 2023.11.13-д магадлал хийсэн нь аймгийн Засаг дарга төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлснээс хойших хугацаа байна. Харин барилгын гадна шугам сүлжээний угсралтын ажлын төсөлд 2024.05.22-нд магадлал хийсэн байна.
Аймгийн засаг даргын төсвийн төсөлд тусгагдсан		
6	Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Завхан, Тосонцэнгэл/	Зураг төсөлд 2023 оны 09 сарын 14-д магадлал хийгдсэн нь аймгийн Засаг дарга төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлснээс хойших хугацаа байна.
7	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Баянхайрхан сум/	Зураг төсөлд магадлалын дүгнэлт 2024.06.04-д хийгдсэн байна.
8	Хүний хөгжлийн ордны барилга /Завхан, Тосонцэнгэл/	Зураг төсөлд магадлалын дүгнэлт 2023.09.15-д хийгдсэн нь аймгийн Засаг дарга Сангийн яаманд төсвийн төсөл хүргүүлснээс хойших хугацаа байна.
9	Хүүхдийн цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Эрдэнэхайрхан/	Зураг төсөлд магадлалын дүгнэлт 2023.11.27-д хийгдсэн нь аймгийн Засаг дарга Сангийн яаманд төсвийн төсөл хүргүүлснээс хойших хугацаа байна.
10	Хүүхдийн цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Түдэвтэй/	Зураг төсөлд 2023.07.19-нд магадлалын дүгнэлт хийгдсэн нь аймгийн Засаг дарга Сангийн яаманд төсвийн төсөл хүргүүлснээс хойших хугацаа байна.
11	Соёлын төвийн барилга, 200 суудалтай /Завхан, Сонгино/	Зураг төсөлд магадлалын дүгнэлт 2023.11.28-д хийгдсэн нь аймгийн Засаг дарга Сангийн яаманд төсвийн төсөл хүргүүлснээс хойших хугацаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, 29¹.2-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх”, 29¹.2.2-д “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх”, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11-д “зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.2-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг

хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй”, 3.2.2.2-д “барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Аудитаар төсөл арга хэмжээний батлагдсан төсвийг магадлалын дүгнэлттэй тулган шалгахад дараах төсөл арга хэмжээний төсөвт өртөг зөрүүтэй байна.

Хүснэгт 4. Батлагдсан төсөвт өртөг магадлалын дүнгээс зөрүүтэй ТАХ /шинэ/
/сая.төг/

д/д	ТАХ-ний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Магадлалын дүн	Илүү/+, дутуу/-
1	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Отгон сум/	2,387.0	4,953.3	-2,596.3
2	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Түдэвтэй сум/	2,615.5	3,154.9	-539.4
3	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Эрдэнэхайрхан сум/	2,615.5	3,612.2	-996.7
4	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Дөрвөлжин сум/	4,512.5	3,831.0	681.5
5	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Сонгино сум/	4,968.0	5,212.3	-244.3
6	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай сум/	28,285.9	35,512.5	-7,226.6
ДҮН		44,207.8	51,337.2	-10,921.8

Зурагт төсөв болон магадлалын дүгнэлт хийгдээгүй байхад төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэг маягийн зураг төсөл болон өөр төсөл арга хэмжээний жишиг магадлалд үндэслэн баталсантай холбоотой зөрүү үүссэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7.3-д “Төсөл, арга хэмжээний гэрээнд тухайн төслийн зураг төслийн магадлалаар баталгаажсан төсөвт өртгийн задаргааны дагуу гэрээний нийт дүнг зардлын нэр төрөл бүр тусгах бөгөөд энэ нь төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртгөөс хэтрэхгүй байна” Монгол улсын ЗГ-ын 2017 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм" -ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Барилгын тухай хуулийн 22, 23, 25, 26 дугаар зүйлд заасан барилга байгууламжийн техникийн нөхцөл авах, зураг төсөл боловсруулах ажлын захиалга өгөх, зураг төсөлд магадлал хийлгэх, барилгын ажлын зөвшөөрөл авах” гэж заасантай нийцээгүй байна.

Дээд шатны төсөв захирагчдын хяналт хангалтгүй, ЗГ, УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган баталдаг байдал шалгадагч байгууллагаас ирүүлсэн тайлбар, аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд ажиглагдлаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй төсөл арга хэмжээ баталсан байна /1.4/

Орон нутагт эрх шилжин шинээр эхэлж буй төсөл арга хэмжээнүүдийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудтай тулган хяналтыг хэрэгжүүлэхэд Улиастай сумын Чигэстэй багийн явган болон дугуйн зам 3.9 км, ногоон байгууламж бүхий орчны тохижилт гэсэн төсөл арга хэмжээнүүд тус хуультай нийцээгүй байна.

Ногоон байгууламж бүхий орчны тохижилт ТАХ нь аймгийн Засаг даргын төсвийн төсөлд тусгагдаагүй, ТЕЗ-ийн шийдвэрээр хэрэгжсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1-д “орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалд, гэрэлтүүлэг, тохижилт” гэсэн заалттай зөрчилджээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой бий болсон нөхцөл байдал, алдаа зөрчлүүд нь ерөнхийдөө ТЕЗ болон Сангийн яамны зүгээс хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хяналт хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна гэж үзлээ. Учир нь орон нутгийн удирдлагууд аймаг сумандаа хөрөнгө оруулалт татахын тулд боломжит бүх хувилбарыг ашиглаж байгаа нь ажиглагдлаа. Гэтэл хяналт тавих эрх бүхий байгууллагууд нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталж байгаа нь уг зөрчил гарах суурийг бий болгож байна гэж үзлээ.

Иймд дээд шатны төсөв захирагчдын хяналтыг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Зорилт 2. Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд гаргасан гомдолтой холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлэх үйл ажиллагаа хугацаа хоцорсон байна /2.1/

Аймгийн Засаг даргын баталсан 2024 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас өөрийн эрхлэх асуудлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 29 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Төсвийн тухай хуулийн 14, 61 дүгээр зүйлийг үндэслэн Завхан аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Хүснэгт 5. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо, жагсаалт

№	Эрх шилжүүлсэн ТЭЗ	Эрх шилжүүлсэн шийдвэрийн огноо, дугаар	ТАХ-ний тоо	Хугацаа хоцроосон хоног
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	2024.01.30-ны өдрийн 11 дүгээр тушаал	4	10
2	Боловсрол шинжлэх ухааны яам	2023.12.05-ны өдрийн А/550 дугаар тушаал	9	
3	Эрчим хүчний яам	2024.01.31-ний өдрийн А/49 дүгээр тушаал	1	11
4	Зам, тээврийн сайд	Засгийн газрын 2023.11.22-ны өдрийн 409 дүгээр тогтоол	2	
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Засгийн газрын 2023.11.22-ны өдрийн 409 дүгээр тогтоол	2	
6	Соёлын сайд	Соёлын сайдын 2023.12.15-ны өдрийн А/499 дүгээр тушаал	5	
7	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Засгийн газрын 2023.11.22-ны өдрийн 409 дүгээр тогтоол	2	
8	Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн сайдын 2024.01.09-ний өдрийн А/12 дугаар тушаал	4	
Хугацаа хоцроосон дундаж хоног			29	10.5

Дээрх эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний 5 буюу 17.2 хувийг 10-11 хоногийн хугацаа хоцроон эрх шилжүүлжээ.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас эрх шилжүүлсэн ихэнх тушаал боломжит хугацаагаар гарсан ч Төрийн худалдан авах ажиллагааны цахим /tender.gov.mn/ системээр эрхийг шилжүүлэх үйл ажиллагаа нь цаг хугацаа их шаарддаг байна.

Эрх шилжүүлэлттэй холбоотой худалдан авах ажиллагааны хугацаанд нөлөөлсөн асуудал аудитаар ажиглагдаагүй болно.

Захиалагчаас зарим үнэлгээний хороог байгуулахдаа хууль, журмыг зөрчсөн, худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай хүсэлтийг оройтож хүргүүлснээс төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа цаг хугацаандаа зохион байгуулагдахгүй байх эрсдэлийг бий болгожээ. Захиалагч нь тендер сонгон шалгаруулах үйл ажиллагаа явуулах хүсэлтийг тухайн төсөл, арга хэмжээний үнэлгээний хороо байгуулагдсан хугацаанаас 35-58 хоногийн дараа Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлжээ.

Аймгийн худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолд заасан төсөвт өртгийн дээд хязгаарт үндэслэн тендер шалгаруулалтын аргыг сонгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, орон нутагт эрх шилжсэн төсөл арга хэмжээнүүдийг нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулах шаардлагатай байна/2.2/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжихээр баталсан 29 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий 11 үнэлгээний хороо байгуулагдсан байна.

Үнэлгээний хороодын бүрэлдэхүүнийг судлан үзэхэд нийт 9 хараат бус гишүүнийг /нэг гишүүнийг дунджаар 6.4 үнэлгээний хороонд/ томилон ажиллуулжээ. Ингэхдээ аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг хараат бус гишүүнээр томилон ажиллуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтууд, Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-тай нийцээгүй байна.

Мөн АЗ гэрчилгээтэй иргэдийн судалгааг гаргаж, бүртгэл хөтлөөгүй нь хараат бус гишүүдийг төрийн алба хаагчдаар томилоход нөлөөлсөн байна. Энэхүү судалгааг гарган, жил бүр шинэчлэн хөтөлж байх нь зүйтэй. Ингэснээр үнэлгээний хороонд иргэд, олон нийтийн төлөөллийг нээлттэй ил тод хамруулан оролцуулах нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

Хүснэгт 6. Үнэлгээний хорооны зохион байгуулсан ХАА-ны тоо

№	Шийдвэрийн он, сар, өдөр, дугаар	Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тоо
1	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 сарын 04-ний өдрийн А/77 дугаар захирамж	4
2	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 сарын 04-ний өдрийн А/78 захирамж	3
3	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 сарын 04-ний өдрийн А/79 захирамж	4
4	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 сарын 04-ний өдрийн А/80 захирамж	4
5	Аймгийн Засаг даргын 2024 оны 04 сарын 09-ний өдрийн А/152 захирамж	5
6	Аймгийн Засаг даргын 2024 оны 04 сарын 09-ний өдрийн А/153 захирамж	1
7	Аймгийн Засаг даргын 2024 оны 04 сарын 18-ний өдрийн А/158 захирамж	3
8	Аймгийн Засаг даргын 2024 оны 05 сарын 15-ний өдрийн 161 захирамж	1
9	Аймгийн Засаг даргын 2024 оны 04 сарын 30-ний өдрийн А/170 захирамж	1
10	Аймгийн Засаг даргын 2024 оны 05 сарын 03-ний өдрийн А/183 захирамж	2

11	Аймгийн Засаг даргын 2024 оны 08 сарын 26-ний өдрийн А/283 захирамж	1
	ДҮН	29

Эдгээр үнэлгээний хороо нь 2024.03.04-2024.08.26-ны хугацаанд тус бүр 1-5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд нэг төрийн албан хаагч болон хараат бус гишүүдийг дахин дахин ажиллуулж байгаа нь тендер шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Цаашид үнэлгээний хорооны хараат бус, бие даасан байдлыг хангах зорилгоор тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилж байх мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50.8-д заасны дагуу тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах чиг үүргийг гүйцэтгэснээр үнэлгээний хорооны чиг үүрэг дуусгавар болохоор зохицуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Тендерийн баримт бичиг боловсруулалтад хяналтыг хэрэгжүүлэхэд дараах нөхцөл байдал ажиглагдлаа.

- ✓ Зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэх ажлыг хууль, журамд заасны дагуу бүрэн хэрэгжүүлээгүй,
- ✓ Тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жишиг баримт бичигт нийцүүлэн боловсруулаагүй,
- ✓ ТББ-ыг зөвхөн үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн дарга нар боловсруулдаг.
- ✓ Тус үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүйгээс дахин тендер зарлаж хугацаа алдах, өрсөлдөөнийг хязгаарлах зэрэг байна.

Тухайлбал:

- Соёлын төвийн барилга 200 суудал /Завхан Отгон сум/, Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Завхан Улиастай/ барилга угсралтын ажлуудын тендерийн баримт бичгийн ТШЗ-18.1, 18.2-д заасан шалгуур үзүүлэлтийг Сангийн сайдын 2023 оны А/259 дүгээр тушаалаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулаагүйгээс Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гомдол гарч тендер шалгаруулах хугацаа алдсан.
- Соёлын төвийн барилга 200 суудал /Завхан Отгон сум/ угсралтын ажлын тендерийн баримт бичгийн ТШЗ 18.2-т заасан шалгуур үзүүлэлтийг боловсруулахтай холбогдон гаргасан гомдлыг ШӨХТГ-аас хянаж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 58.5.2-т заасны дагуу зөрчлийг арилган тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг даалгасан боловч дээрх тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулалгүйгээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн зохион байгуулсан.

- Мөн дээрх гомдолд дурдсан “Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн эрх нээсэн гэрээ (зээлийн эрх нээсэн гэрээний хугацаа дуусаагүй байх) ирүүлэх” гэж заасан шалгуур үзүүлэлт нь өрсөлдөөн хязгаарласан гэж хянасан шийдвэрийг ШӨХТГ-аас гаргасан боловч аймгийн ХААГ-аас дээрх шалгуур үзүүлэлтийг бусад тендер шалгаруулалтын баримт бичгүүдэд тусган тендер шалгаруулалтуудыг зохион байгуулж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5.1-д заасан худалдан авах ажиллагааны өрсөлдөх тэгш боломжтой байх зарчимтай нийцээгүй байна.

Тайлант онд зохион байгуулсан бүх худалдан авах ажиллагаанд гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардах шалгуур үзүүлэлтийг тендерийн баримт бичигт тусгасан байна.

Тендерийн баримт бичигт санхүү, техникийн чадавх болон туршлагын шаардлага, шалгуур үзүүлэлтийг оновчтой тусгаагүйгээс тендер шалгаруулалт амжилтгүй болох нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

- ✓ Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт шаардахдаа хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож заагаагүй;
- ✓ Ажил гүйцэтгэх тендерийн баримт бичгүүдэд “Ерөнхий инженер хамгийн багадаа удаа батлагдсан төсөвт өртгийн ... хувиас багагүй гэрээний үнийн дүнтэй ижил төстэй ажлыг Улсын комисст хүлээлгэн өгсөн туршлагатай байх. Улсын комисст хүлээлгэн өгсөн ажлын гэрээ, дүгнэлт, хүлээлгэн өгсөн комиссын акт ирүүлэх” гэж тусгасан боловч барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтэд ерөнхий инженер гарын үсэг зурж баталгаажуулдаггүй тул тус шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг бүрэн нотлох боломжгүй нөхцөл байдал үүссэн;
- ✓ “Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Шаардана. а) Тендерт санал болгосон инженер техникийн ажилтнуудын дээш хувь нь одоо хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан дуусаагүй ажилд давхацсан тохиолдолд татгалзана” гэх шалгуур үзүүлэлтийн нотлох баримтыг тодорхой тусгаагүй;
- ✓ Зарим тендерийн баримт бичгүүдэд ажил гүйцэтгэх хүний нөөцийн ажилласан жилийн туршлага, мэргэжил, хүчин төгөлдөр нотлох баримтууд болон тоног төхөөрөмжийн шаардлага хангасан эсэхийг нотлох баримтыг бүрэн, оновчтой шаардаагүйгээс тус шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг нотлоход хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэсэн;
- ✓ Түншлэлийн гишүүн бүрийн гүйцэтгэх үүрэг тендерийн үнийн 20 хувиас дээш байх, шаардлага хангасан гэрээг ирүүлэх шалгуур үзүүлэлт болон гишүүн тус бүрийн болон хамтдаа хангавал зохих санхүүгийн чадавх, техникийн чадавх, туршлагын доод шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт тодорхой тусгадаггүй;
- ✓ Тендер шалгаруулалтын баримт бичгийн гэрээний нөхцөлийг бүрэн боловсруулдаггүй зэрэг нийтлэг зөрчлүүд байна.

Иймд цаашид тендерийн баримт бичиг боловсруулах үнэлгээний хороо нь захиалагчаас ирүүлсэн төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг хянаж Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-ын 4.6-д "Үнэлгээний хороо бараа, ажил, үйлчилгээний онцлогоос хамааруулан төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жишиг баримт бичигт нийцүүлэн тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлт, тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой тодруулгын төслийг боловсруулж, хууль тогтоомжид нийцүүлэн батлуулахаар захиалагчид хүргүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллах албан шаардлагыг аймгийн ХААГ-т хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулаагүй, шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна /2.3/

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2023 оны А/482 дүгээр захирамжаар Худалдан авах ажиллагааны газрыг байгуулсан бөгөөд худалдан авах ажиллагааг зохион байгуулах албан хаагчид томилогдон ажиллаагүй байсны улмаас тайлант оны худалдан авах ажиллагааг ХАА-ны төлөвлөгөөнд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр баталсан 129,753.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэн зохион байгуулж 2.3 тэрбум төгрөгийн хэмнэлтийг гарган ажилласан байна.

Хүснэгт 7. ТАХ-ний ХАА-г зохион байгуулсан тоо, төсөвт өртөг, тендерийн хэмнэлт /сая.төг/


Ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Санхүүжих дүн /сая.төг/	Шалгарсан үнийн дүн /сая.төг/	Тендерийн хэмнэлт /сая.төг/
Барилга, байгууламж	23	124,653.5	25,475.72	122,572.0	2,21.4
Тоног төхөөрөмж	6	5,100.00	5,100.00	4,868.40	231.60
ДҮН	29	129,753.40	30,575.20	127,440.40	2,353.00

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн ХАА-ны тайлан

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа дунджаар ажлын 56 хоногийг, худалдан авах ажиллагааны гэрээ байгуулахад дунджаар ажлын 6 хоногийг зарцуулжээ.

Худалдан авах ажиллагаа зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан хугацааг сараар авч үзвэл, 2024 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний 68 хувийн гүйцэтгэгчийг 4-6 дугаар саруудад шалгаруулсан байна.

График 1. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хугацаа (хувь, сараар)



Үнэлгээний хороо нь оролцогчдоос ирүүлсэн тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянаж, үнэлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллаагүйгээс зарим сонгон шалгаруулах үйл ажиллагаа хууль, журмын хүрээнд зохион байгуулагдаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 29 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 3 тендер шалгаруулалтыг 2 удаа, 8 тендер шалгаруулалтыг 3-аас дээш удаа зохион байгуулсан байна.

Энэ нь оролцогч материал ирүүлээгүй, шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг бүрэн судалж тендерийн баримт бичигт оролцогчид тавих шаардлага, шалгуур үзүүлэлтэд өөрчлөлтийг тусгаагүй, тендерийн баримт бичгийг хууль, жишиг баримт бичигт нийцүүлэн боловсруулаагүй зэргээс шалтгаалсан байна гэж үзлээ.

Улсын төсвийн ХО-аар хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журам, тендерийн баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй 26 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулжээ.

Хүснэгт 8. Хууль, журамд нийцүүлэн үнэлээгүй ТАХ-ний тоо
(Дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт-аас харна уу)

№	Хууль, журамд нийцээгүй үндэслэл	Төсөл, арга хэмжээний тоо /давхардсан/
1	Оролцогчийн ерөнхий шаардлагыг хангаагүй	1
2	Хуулийн 6 дугаар зүйл, ТББ-т тусгасан түншлэлийн шаардлага хангаагүй	5
3	Хуулийн 16 дугаар зүйл, ТББ-т тусгасан санхүүгийн чадавхын шаардлага хангаагүй	12
4	Хуулийн 17 дугаар зүйл, ТББ-т тусгасан техникийн чадавх, туршлагын шаардлага хангаагүй	19
5	Тендерийн баримт бичигт шаардсан тусгай зөвшөөрөлгүй	1
6	Төсөвт зарим зардлыг тусгаагүй, ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарь ирүүлээгүй	4
7	Үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотой журмыг дагаж мөрдөөгүй	9
	ДҮН	51

Зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэх ажлыг хууль, журамд заасны дагуу бүрэн хэрэгжүүлээгүй, тендерийн саналыг үнэлэх, эрх олгох үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүйгээс дахин тендер зарлаж хугацаа алдах, өрсөлдөөнийг хязгаарлах байдал ажиглагдлаа.

Захиалагчаас тендерт оролцогчийн санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт болох “Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээний дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн эрх нээсэн гэрээ ирүүлэх” гэсэн шалгуур үзүүлэлтийг тендерийн баримт бичигт тусган шаардаж байгаа боловч тендерт оролцогчдын ирүүлж буй харилцагч банкны тодорхойлолтуудыг шаардлагад нийцсэн, нийцээгүй зэргээр үнэлж байна.

Тухайлбал: “Цэнхэр тэнгэрийн орон оч” ХХК-ийн тендерийн баримт бичигт ирүүлсэн Хас банкны ижил утга бүхий 2 тодорхойлолтыг хянаж үнэлэхдээ Тэс сумын Цэцэрлэгийн барилга угсралтын тендер шалгаруулалтад шаардлагад нийцсэн, Сонгино сумын Соёлын төвийн барилга угсралтын тендер шалгаруулалтад шаардлагад нийцээгүй гэж үнэлж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүдтэй нийцэхгүй байна.

Захиалагч тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 25, 51 дүгээр зүйлд заасны дагуу тодруулга авч болохоор тусгасан боловч зарим оролцогчоос ирүүлсэн тендерт тодорхойгүй, зөрчилдөөнтэй асуудал үүссэн тохиолдолд оролцогч болон бусад холбогдох байгууллагаас тодруулж, хянан үзэж, үнэлгээ хийгээгүйгээс тендер шалгаруулалт амжилтгүй болох, дахин зарлах, гомдол гаргах, төсөл арга хэмжээ цаг хугацаандаа хэрэгжихгүй байх үндэслэл, шалтгаан болж байна.

Аудитаар худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг боловсруулсан, дахин зарласан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг журмын дагуу бүрэн гүйцэд хөтлөөгүй, эсвэл тендерийн үнэлгээний хороо хуралдаагүй, мөн зарим тэмдэглэлд хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, үнэлгээний хорооны зарим гишүүд уг хуралд оролцсон эсэх нь эргэлзээтэй тендерийг хянан үзээгүй зэрэг нийтлэг зөрчил илэрлээ.

Иймд цаашид үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулах болон тендерийг хянаж, үнэлэхдээ бүх гишүүдийн оролцоог хангах, хурлын тэмдэглэлийг журмын дагуу бүрэн гүйцэд үнэн зөв хөтлөн зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн ХААГ-т хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Үнэлгээний хорооны шийдвэрүүд нь худалдан авах ажиллагаанд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, хариуцлагатай байх зарчмуудтай нийцээгүй, оролцогчдод давуу байдал олгосон, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байж болзошгүй байна.Тухайлбал:

- Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн ажлын тендерийг үнэлэхдээ үнэлгээний хорооны 3 гишүүн нь шаардлагад нийцсэн тендер ирээгүй гэж, 1 гишүүн нь өөр ХХК-ийг хамгийн сайн тендер ирүүлсэн гэж, 5 гишүүн нь ТББ-т заасан санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангаагүй, ажлын тоо хэмжээ зөрүүтэй оролцогчийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн гэж үнэлсэн;

- Отгон сумын Соёлын төвийн барилга угсралтын ажлын тендер шалгаруулалтыг 3 дахь удаагаа зохион байгуулахад шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн гэж үнэлсэн “Силикон арт дизайн” ХХК-ийг 4 дэх сонгон шалгаруулалтад оролцоход тус тендер шалгаруулалтын ТББ-т заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй байхад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн гэж үнэлсэн зэрэг нь дээрх үнэлгээний хороо оролцогчдод давуу байдал олгосон, ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй байх тул энэхүү 2 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэх саналыг ҮАГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

Улсын төсвийн ХО-ын худалдан авах ажиллагаатай холбоотой 8 /нийт тендер шалгаруулалтын 27.5%/ гомдол гарснаас тендер шалгаруулалтын баримт бичиг өрсөлдөөн хязгаарласан тухай 2 гомдлыг ШӨХТГ-т, захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр 6 гомдлыг Сангийн яаманд гаргасан нь 2023 оноос 4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Сангийн яам тендерт оролцогчдоос гаргасан 6 гомдлыг хянаж үзээд холбогдох шийдвэрийг аймгийн ХААГ-т хүргүүлсэн боловч дараах 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо Сангийн яамнаас гаргасан шийдвэрийн хүрээнд зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Үүнд:

- Улиастай сумын Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын тендерт оролцсон оролцогчоос гаргасан гомдлыг Сангийн яам 2024.08.06-ны өдрийн 03/6591 дугаартай Гомдол хянасан тухай албан бичгээр “дулааны инженерийн ажилласан жилийн шаардлага хангаагүй, хөлсөөр ажиллуулах гэрээнд нөхцөлийг тодорхой тусгаагүй нь шаардлагад нийцсэн гэж үнэлсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй” гэж хянан үзэж, захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгож хуулийн 59.10.2-т “зөрчлийг арилган, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг даалгах” гэж шийдвэрлэжээ. Тус ажлын үнэлгээний хороо 2024.08.19-ний өдөр хуралдан Сангийн яамнаас захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгоогүй учир дахин үнэлэхгүй гэх шийдвэрийг үнэлгээний хорооны гишүүдийн олонхын саналаар гаргасан;
- Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд техник тоног төхөөрөмж худалдан авах тендерт оролцсон оролцогчоос гаргасан гомдлыг Сангийн яам 2024.06.10-ны өдрийн 03/4871 дугаартай Гомдол хянасан тухай албан бичгээр “.... тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна”, “... холбогдох байгууллагаас нь тодруулж нягталж үзэх нь зүйтэй байна”, “...захиалагчаас тодруулж, хянан үзэх нь зүйтэй байна”, “Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье” гэж шийдвэрлэсэн байна. Үнэлгээний хороо 2024.06.24-ний өдөр хуралдаж тус тендерийг дахин хянаж үнэлэхдээ гомдол хянасан шийдвэрт заасан асуудлуудаар холбогдох байгууллагуудаас тодруулаагүй, мөн “Бэст вүүдэн хаус” ХХК-ийн тендерт ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээллийг ирүүлсэн байхад татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж Сангийн яам хянасныг харгалзалгүйгээр үнэлгээг хийсэн;
- Зам, тээврийн сайдаас эрх шилжүүлсэн Богд, Чигэстэйн голын төмөр бетон гүүр, 290.03 у/м /Завхан, Улиастай сум/ барих ажлын тендер шалгаруулалтад

оролцогчоос Сангийн яаманд гомдол гаргаж тус яамнаас 2024.06.11-ний өдрийн 03/4914 дугаартай гомдол хянасан тухай албан бичигт “... Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас тодруулж үнэлгээ хийж Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.9-д заасныг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллана уу” гэж шийдвэрлэжээ. “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 3.9 дэх хэсэгт “Хуульд заасан гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага, эсхүл шүүхээс тендер шалгаруулалтын баримт бичиг өөрчлөлт оруулах, эсхүл тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг дахин хийх, эсхүл захиалагчийг тендерийн үнэлгээний хорооны зөвлөмжид хяналт тавихыг даалгасан тохиолдолд захиалагч үнэлгээний хороог хуралдуулж шийдвэр гаргана” гэж заасны дагуу үнэлгээний хорооны 2024.06.11-ний өдрийн 03 дугаар хурлын тэмдэглэлд /хурлын тэмдэглэлийн огноог 2023.06.11 гэж бичсэн/ гомдол хянасан албан бичигт дурдсан асуудлаар Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас тодруулж үнэлгээ хийх, үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих талаар хэлэлцээгүй. Мөн энэхүү тендер шалгаруулалтад оролцогчоос Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд 2024.10.28-нд тус нэхэмжлэлээсээ татгалзсан байна.

Дээрх 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хороод оролцогчдод давуу байдал олгосон, ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн зөрчилд ТЕЗ-д албан шаардлага, Сангийн яаманд гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг ЯАГ-аар дамжуулан хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Зорилт 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлэн хүлээн аваагүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлжээ. /3.1/

Орон нутагт эрх шилжсэн 35 төсөл арга хэмжээний санхүүжилтэд нийт 39,401.7 сая төгрөг батлагдсанаас 32,650.4 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосон нь 6,751.3 сая төгрөгөөр дутуу байна. Харин аймгийн засаг дарга гүйцэтгэгч байгууллагуудад 29,970.2 сая төгрөгийг барилгын ажлын гүйцэтгэлд үндэслэн олгож 2,680.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.

Өмнөх онд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийн олголтыг тулган үзэхэд дотуур байрын барилга /Асгат сум /-ын 63.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

Хүснэгт 9. Барьцаа хөрөнгийн дансанд үлдэгдэлтэй ТАХ
Сая.төг

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн /сая.төг/
1	Дотуур байрны барилга /Асгат сум/	63.7
2	Сумын төвийн хатуу хучилтай авто зам 3км /Завхан, Их-уул/	214.65
3	Хөгжимт жүжгийн театрын барилга /Завхан, Улиастай/	1,941.04

4	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Түдэвтэй сум/	103.99
5	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Нөмрөг сум/	70.56
6	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Отгон сум/	349.98
	ДҮН	2,743.92

Дараах төсөл арга хэмжээнүүдийн гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хийгдээгүйн улмаас батлагдсан төсвийн улсын төсвөөс олгоогүй байна.

Хүснэгт 10. Батлагдсан төсөвт зохицуулалт хийсэн ТАХ /шинэ/ сая.төг

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв	Олгосон дүн	Тайлбар
1	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан,Дөрвөлжин/	1,065.7	0	Барилга угсралтын ажлыг 2024 онд эхлүүлээгүй байна.
2	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Эрдэнэхайрхан сум/	784.7	418.6	ТЕЗ төсөвт зохицуулалт хийсэн
3	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Отгон сум/	1,193.5	350.0	Гүйцэтгэгчтэй 2024 оны 11 сард гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил эхлээгүй тул төсөв олгогдоогүй
4	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай/	6,485.8	2,900.7	Барилга угсралтын төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл хангалтгүй байсан тул төсөв татагдсан
5	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Баянхайрхан сум/	600.0	0	Гүйцэтгэгчтэй 2024 оны 11 сард гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил эхлээгүй тул төсөв олгогдоогүй
	ДҮН	10,129.7	3,669.3	

Тухай жилд батлагдсан төсвийг бүрэн авч чадахгүй татуулсан нь төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгож байна. Иймд төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, барилга угсралтын ажлыг дулааны улиралд эхлүүлж байх шаардлагатай байна.

2024 онд орон нутагт эрх шилжсэн 35 төсөл арга хэмжээний 21 нь дараа онд шилжих төсөл арга хэмжээ байна. Эдгээрээс 18 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 5-15 хувьтай, зөвхөн газар шороо, суурийн ажил хийгдсэн байдалтай, 3 төсөл арга хэмжээний ажил эхлээгүй байна. Үүнд:

1. Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Дөрвөлжин/: Гүйцэтгэгчтэй 2024 оны 08 сарын 05-д гэрээг байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх талаар ГХБХБГ-аас удаа дараа шаардлага тавьсан ч ажлаа эхлүүлээгүй гэсэн тайлбар өглөө.
2. Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Баянхайрхан сум/: Тендер сонгон шалгаруулалттай холбоотой гомдол гарсны улмаас гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг хүйтний улирал буюу 2024.11.24-д байгуулсан тул ажил эхлээгүй байна.

3. Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Отгон сум/ шаардлага хангасан оролцогч тендер шалгаруулалтад ороогүйн улмаас худалдан авах ажиллагааг 4 удаа зохион байгуулжээ. Ингэхдээ шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулж, 2024 оны 11 сард гэрээ байгуулсны улмаас ажил эхлээгүй байна.

Ийнхүү гэрээг хүйтний улиралд байгуулж байгаа нь Төсвийн тухай хуульд батлагдсан төсвийг буцаан татуулахгүйн тулд ямар нэгэн хуулийн этгээдтэй зайлшгүй гэрээ байгуулах шаардлага гардаг байна. Энэ нь шаардлага хангахгүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үндэслэл болж байна. Иймд Сангийн яам нь нэгэнт батлагдсан төсвийг буцаан таталгүй орон нутгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулан, гүйцэтгэлд хяналт тавих эрх зүйн орчин шаардлагатай байна гэж үзлээ.

Эдгээр төсөл арга хэмжээтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг аудитын тайлангийн хавсралт “Ерөнхий мэдээлэл”-ээс харах боломжтой.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй, гэрээний хугацааг сунгасан байна. /3.2/

Орон нутагт эрх шилжсэн 35 төсөл арга хэмжээний 14 нь 2024 онд хэрэгжих төсөл арга хэмжээ байна. Үүний 6 нь өмнөх оноос шилжих, 8 нь тайлант хугацаанд хэрэгжих төсөл арга хэмжээ байна.

Тайлант онд дуусах 8 төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд хүлээн авсан бөгөөд өмнөх оноос шилжин хэрэгжиж буй 3 төсөл арга хэмжээ нь гэрээний хугацаанд хийгдээгүй, хугацаа сунгасан байна. Үүнд:

1. Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3км /Завхан, Их-уул сум/: Тус ажил нь 1,998.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр 2019 оны 07 дугаар сарын 26-нд баригдаж эхлэн 2021 оны 08 дугаар сарын 01-нд дуусгахаар гэрээ байгуулсан байна. 2020 онд уг замын ажлын зураг төсөв өөрчлөгдсөн шалтгаанаар ажил бүрэн хийгдэж дуусаагүй байснаас Сангийн яам үлдэгдэл 214.6 сая төгрөгийн санхүүжилтийг буцаан төвлөрүүлснийг 2024 онд олгосон байна. Уг санхүүжилтийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ. 2022 онд магадлалын ерөнхий



дүгнэлтээр материалын үнийн өсөлтийг 26.7 сая төгрөгөөр хянасныг 2023 онд бүрэн олгожээ. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулж гэрээний хугацааг 2025 оны 10 сарын 30 болгон сунгажээ. Тус төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нь төсөвт өртгийг нэмэгдүүлэх дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын байгууллагад хандсан байна.

2. Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан, Улиастай/: Тус



барилгын төсөвт өртөг 19,410.4 сая төгрөг бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90.9 хувьтай байна. Уг төсөл арга хэмжээг 2024 оны 11 сард хүлээн авхаар гэрээлсэн ч хугацаандаа хийгдээгүй байна. Энэ нь интерьер, тайз, технологийн ажлуудыг БНХАУ-д хийлгүүлэх, тээвэрлэх, ажиллах хүчний /хятад иргэд/ виз гарахгүй хугацаа алдсан зэргээс ажил хойшилж эхэлсэнтэй холбоотой гэсэн тайлбар өглөө. Аудитын

явцад барилга угсралтын ажилтай танилцахад тайз, технологийн ажил хийгдсэн, интерьер заслын ажил хийгдэж байна. 2024 онд олгох санхүүжилтийн 1,941.0 сая төгрөгийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, барилгын ажлыг 2025 оны 06 сарын 01-нд хүлээн авахаар гэрээг сунгасан байна.

3. Соёлын төвийн барилга, 200 судал /Завхан, Нөмрөг/: Төсөл арга хэмжээний гүйцэтгэл 70.5 хувьтай бөгөөд 2024 онд батлагдсан 70.6 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 2024 онд нэмэгдүүлсэн нь материалын үнийн өсөлттэй холбоотой байна. Харин төсөвт өртгийг дахин 1,419.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж магадлалын дүгнэлтийг 2025 онд хийсэн байна. Уг төсвийг 2026 оны төсөвт тусгуулахаар саналаа ССАЖЗЯ-д хүргүүлжээ. Ийнхүү төсөвт өртгийг нэмэгдүүлсэн нь анхны зураг төсөвт тайз, технологи, акустик, гадна зам талбайн тохижилтын ажлыг тусгаагүйтэй холбоотой гэсэн тайлбар өглөө.



Эдгээр төсөл арга хэмжээнээс гадна өмнөх онд хэрэгжиж дуусах Жавхлант цогцолбор сургуулийн спорт заалны барилга угсралтын ажлыг хүлээн аваагүй байна. Энэхүү барилгыг хүлээн авч, данс бүртгэлд тусгах зөвлөмжийг өмнөх оны аудитаар хүргүүлсэн ч хэрэгжээгүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Уг барилга угсралтын ажлын гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар Боловсролын ерөнхий газраас тоот ирүүлжээ. Аймгийн Засаг дарга болон холбогдох бусад эрх бүхий байгууллагуудын зүгээс тус хуулийн этгээдийн ажлыг гүйцэтгүүлэх, хариуцлага тооцох арга хэмжээ аваагүй, 2025 оны 05 сарын 01-нд хүлээн авах аман тохиролцоонд хүрсэн байдалтай байна. Уг барилга угсралтын ажлын 640 хүүхдийн хичээлийн байрны барилгыг 2021 онд хэсэгчилсэн байдлаар улсын комисст хүлээн авч, спорт заалны ажлыг хүлээн аваагүй бөгөөд одоог хүртэл ажил дуусаагүй байна. Аудитаар уг барилгын гүйцэтгэлтэй танилцахад шал, дотор заслын дутуу ажлуудыг хийж байлаа.

Мөн өмнөх оноос орхигдсон Асгат сумын дотуур байрны барилгын ажил байна. Барилга угсралтын ажил 40 орчим хувьтай зогсжээ. Анх барилга баригдахаа зураг төсөвгүй эхэлж, 2022 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөгдсөн боловч барилгын материалын үнийн өсөлт, COVID-19 өвчний улмаас шалтгаалан тухайн онд бүрэн хэрэгжиж дуусаагүй байна. 2024 оны байдлаар барилгын зөрүү ажилд 837.6 сая төгрөгийн магадлалын дүгнэлт хийлгүүлсэн, 2026 оны төсөвт тусгуулахаар ажиллаж байна гэсэн тайлбарыг өглөө.



Энэ нь Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.6-д “Энэ хуулийн 32.1.5, 33.1.23-т зааснаас бусад барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, 37 дугаар зүйлийн 37.1-д “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.6-д “энэ хуулийн 48.1-д заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах”, 48.1-д “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэсэн заалтуудтай болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний холбогдох заалттай нийцээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй байхад хүлээн авсан байна. /3.3/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 10 төсөл арга хэмжээг хүлээн авч, гэрээг дүгнэсэн байна.

Улсын комисс хүлээн авсан төсөл арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолттой тулган шалгалаа.



1. Сумын төвийн цэвэр усны шугам сүлжээ /Завхан, Тосонцэнгэл сум/: Уг ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгүүлэн хүлээн авсан байна. Барилга угсралтын ажлын хүрээнд 1280м цэвэр усны шугам, 300м³ болон 500м³ усан сангийн дотор засал, цэвэр усны худаг шинэчлэх ажил хийжээ. Энэ нь сумын цэвэр усны нөөцийг бүрдүүлэх зориулалттай байна. Тус төсөл арга хэмжээ нь ТЕЗ-ийн шийдвэрээр хийгдсэн ажил байна.

2. Ногоон байгууламж бүхий орчны тохижилт: Уг ажлын хүрээнд 7 суманд 8

ногоон байгууламж бүхий талбайг хийж гэрээний хугацаанд хүлээн авч, гэрээг дүгнэсэн байна. Уг төсөл арга хэмжээний зураг төсөв тухайн ажлыг хийж дуусах шатанд хийгдсэн байхад барилга байгууламж хүлээн авах комисс төсөл арга хэмжээг зураг төсвийн дагуу хийгдсэн гэж үзэн хүлээн авсан нь учир дутагдалтай байна. Аудитаар бодит байдалд хяналтыг хэрэгжүүлэн ажиллахад ногоон байгууламжийг хийгээгүй байхад дулааны улиралд хийх үүрэг даалгавар өгч хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгожээ.



Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 “Барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна”, 14.1.1-д “зураг төслийн дагуу баригдсан байх”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 5.1.2-д “Барилгын тухай хуулийн 14.1, 14.2 дугаар хэсэгт заасан шаардлага хангагдсан эсэхийг дүгнэх”, 5.1.3-д “барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх”, Монгол улсын ЗГ-ын 2017 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм” -ийн 3 дугаар зүйлийн 3.16-д “Барилгын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн, захиалагч болон эрх бүхий байгууллагын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй. Энэ тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон хөрөнгө оруулагч санхүүжилт олгохгүй байж болно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Ийнхүү үүрэг даалгавар өгч хүлээн авдаг зөрчил арилахгүй байна. Шалтгааныг тодруулахад:

- ✓ Гэрээний хугацааг хүйтний улиралд дуусахаар байгуулсан нь гадна тохижилт, зүлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд тохиромжгүй байдаг
- ✓ Гэрээний хугацаанд хүлээн аваагүй нөхцөлд батлагдсан санхүүжилт эргэн татагдах, нэгэнт татагдсан төсвийг дахин олж авахад цаг хугацаа их шаардагддаг
- ✓ Барилга байгууламжийн хувьд хүйтний улиралд гэрээний хугацаа дуусаж байгаа нөхцөлд ашиглалтын зардлыг хэрхэн шийдвэрлэх тухай асуудал гардаг зэрэг шалтгааны улмаас үүрэг даалгавар өгч хүлээн авдаг гэсэн тайлбар өглөө.

Иймд цаашид дараах асуудалд анхаарах нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал:

- ✓ Гэрээний дуусах хугацааг тухайн барилгын ажлыг хүлээн авахад тохиромжтой хэлбэрээр байгуулах
- ✓ Үүрэг даалгавар өгч хүлээн авч байгаа нөхцөлд санхүүжилтийн тодорхой хэсгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулан, ажил бүрэн дууссаны дараа олгодог байх зохицуулалтыг хийх шаардлагатай гэж үзлээ.

3. Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Түдэвтэй сум: Барилга угсаралтын ажлыг хүлээн авч, гэрээ дүгнэсэн байна. Барилгын төсөвт 2 удаа магадал хийж өртгийг нэмэгдүүлсэн байна. Үүнд: 2022 онд материалын үнийн зөрүү тооцож 333.2 сая төгрөгөөр, 2024 онд зураг төсөвт тусгагдаагүй тайз технологи, акустик, гадна зам талбайн тохижилтын ажлын зураг төсөвт магадал хийж өртгийг 1,071.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр хянасан байна. Тус барилгын төсөвт өртөг 2,603.8 сая төгрөг болж байна. Гэтэл 2024 оны Төсвийн тухай хуульд төсөвт өртгийг 2,081.2 сая төгрөгөөр баталж барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авсан байна. Төсөвт өртгийг бууруулан баталсан талаар холбогдох байгууллагуудаас тайлбар авахад төсөвт гадна тохижилтын санхүүжилтийг тусгаагүй бөгөөд уг ажлын санхүүжилтийг төсвөөс хасаж тооцон ажлыг гүйцэтгүүлж хүлээн авсан, уг зардлыг 2026 оны төсөвт суулгуулахаар ажиллаж байна гэсэн тайлбар өглөө. Төсөл арга хэмжээг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байхад хүлээн авсан байна.



Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 “Барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна”, 14.1.1-д “зураг төслийн дагуу баригдсан байх”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 5.1.2-д “Барилгын тухай хуулийн 14.1, 14.2 дугаар хэсэгт заасан шаардлага хангагдсан эсэхийг дүгнэх”, 5.1.3-д “барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.




4. Хүүхдийн цэцэрлэгийн барилга /Баянхайрхан/: Уг ажлыг бүрэн дуусган ашиглалтад хүлээн авсан байна. Төсөл арга хэмжээ нь өмнөх оны төсөвт тусгагдаагүй орхигдсон барилга бөгөөд төсөвт магадлал хийгдэж 2024 нэмэлт төсөв 887.0 сая төгрөгийг олгосон байна.

5. Мичид кино театрын тоног төхөөрөмж: Мичид кино театрын хуучин барилгыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан бөгөөд тоног төхөөрөмж нийлүүлэх ажил нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн байна. Гэсэн хэдий ч тухайн кино театрын барилгыг шинээр барих, их засвар хийх эсэх нь тодорхойгүй байхад тоног төхөөрөмжийг урьдчилан бэлтгэсэн нь учир дутагдалтай байна. Кино театрын тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд сандал, лед дэлгэц, чанга яригч, өсгөгч



зэрэг 367ш тоног төхөөрөмж хүлээн авч Завхан аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дансанд тусгасан байна.

6. Боловсролын салбарын тоног төхөөрөмж худалдан авах ажлын хүрээнд 312ш зөөврийн компьютер /дагалдах хэрэгслийн хамт/ нийлүүлэгдсэн байна. Эдгээр тоног төхөөрөмжийг 38 хүүхдийн цэцэрлэгийн багш, 6 ерөнхий боловсролын сургуулийн багш, боловсрол шинжлэх ухааны боловсролын мэргэжилтэн нарт олгосон байна.




7. Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл/Завхан/, Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Завхан, Өвөрхангай, Хэнтий/ гэсэн ижил төрлийн 2 төсөл хэрэгжүүлж гэрээний хугацаанд хүлээн авсан байна. Уг ажлуудын хүрээнд газар тариалан эрхлэх зориулалттай техник, тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. / Дэлгэрэнгүй мэдээллийг тоног төхөөрөмж, техник хэрэгслийн судалгаанаас харах/ Эдгээр тоног төхөөрөмжийг 16 сум, 1 төсөвт байгууллагад/Хилийн цэргийн 0277 дугаар анги/ хуваарилжээ. Уг төслийн хүрээнд газар тариалан эрхлэгч иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор техник, тоног төхөөрөмж нийлүүлсэн байна. Гэтэл төсөвт байгууллагад олгосон нь учир дутагдалтай байна гэж үзлээ.



8. Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж худалдан авах ажлын хүрээнд 156 ш компьютерийг гэрээний хугацаанд нийлүүлж, гэрээг дүгнэжээ. Уг нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг сумдын эрүүл мэндийн төвийн дарга, багийн эмч, эрүүл мэндийн салбарын бусад байгууллагуудад олгосон байна



9. Эрчим хүчний тусгай зориулалтын тоног төхөөрөмж, ухаалаг тоолуур худалдан авах ажлын хүрээнд 2260ш ухаалаг тоолуур нийлүүлэгдсэн байна. Эдгээр тоолуурыг Улиастай, Цагаанхайрхан, Яруу сумдын айл өрхүүдэд суурилуулсан байна. Тухайн тоолуурыг ашигласнаар цахилгаан эрчим хүчний хэрэглээнд тухай бүр хяналт тавих, хангагч хэрэглэгчийн хооронд гарах аливаа маргаан, эрчим хүчний алдагдал буурах зэрэг ач холбогдолтой гэсэн тайлбарын өгсөн.



Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгасан байна /3.4/

2024 онд хүлээн авсан 10 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгасан байдал, зориулалтын дагуу ашиглаж буй эсэхэд хяналтыг хэрэгжүүлэхэд дараах нөхцөл байдалтай байна.

Хүснэгт 11. Нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдээлэл

д/д	ТАХ-ний нэр	НББ-д тусгасан эсэх	Тайлбар
1	Сумын төвийн цэвэр усны шугам сүлжээ /Завхан, Тосонцэнгэл сум/	үгүй	Хуучин шугам сүлжээг сэргээн зассан тул данс бүртгэлд тусгаагүй байна. /капиталжуулах шаардлагатай/
2	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт	үгүй	7 суманд 8 талбай байгуулснаас ,,,,, данс бүртгэлд тусгасан байна.
3	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Түдэвтэй сум/	үгүй	Барилгын ажлын данс бүртгэлд тусгаагүй ТӨБЗГ-ын шийдвэрийг хүлээж байна.
4	Баянхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг	үгүй	Барилгын ажлын данс бүртгэлд тусгаагүй ТӨБЗГ-ын шийдвэрийг хүлээж байна.
5	Мичид кино театрын тоног төхөөрөмж	тийм	Гэр бүл хүүхэд залуучуудын газрын дансанд бүртгэсэн байна.
6	Боловсролын салбарын тоног төхөөрөмж	тийм	Тосонцэнгэл сумын 5-р цэцэрлэг 1, БШУГ-т 1 компьютер тус тус бүртгэлгүй байсныг аудитын хугацаанд данс бүртгэлд тусгууллаа.
7	Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө”	тийм	Нөмрөг, Баянтэс сумд хуулийн этгээдэд гэрээгээр олгосон байна.
8	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж	тийм	Төсөвт байгууллагууд данс бүртгэлд тусгасан байна.
9	Эрчим хүчний тусгай зориулалтын тоног төхөөрөмж, ухаалаг тоолуур худалдан авах	тийм	Алтай Улиастай эрчим хүч ТӨХК эзэмшиж байна.

2024 онд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг тухай бүр данс бүртгэлд тусгасан байна. Тоног төхөөрөмжийн ашиглалтын байдлыг судлан үзэхэд:

- Мичид кино театрын тоног төхөөрөмж ашиглалтгүй, агуулахад хураалгаатай байна.
- Орон нутгийн хөгжлийн дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хөдөө аж ахуйн газар тариалангийн зориулалттай тоног төхөөрөмжүүд өмнөх онтой давхардсан, зарим сумдад ашиглалт хангалтгүй байна. Үүнд:

Асгат суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд “Шинэ хөдөө” төслийн хүрээнд газар тариалангийн зориулалттай трактор, хадуур, тармуур, үрлүүр, анжис, хамаг боогч зэрэг нэр төрлийн техник, тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнийг тус сумын газар тариалан эрхлэгч хуулийн этгээд болох “Жавхлант шим” ХХК-д гэрээгээр эзэмшүүлсэн байна. Гэтэл 2024 оны хөрөнгө оруулалтын хүрээнд мөн суманд тармуур, хаман боогч, хадуур гэсэн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн нь давхардсан, ашиглалтгүй байна.

Зарим сумдад дагалдах тоног төхөөрөмжгүй зөвхөн трактор олгосон нь газар тариалан эрхлэх нөхцөлийг хангахгүй байна гэж үзлээ.

Баянтэс, Нөмрөг, Түдэвтэй сумд газар тариалан эрхлэгч хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байна. Ингэхдээ газар тариалан эрхлэгч аж ахуй нэгжүүдийн дунд сонгон шалгаруулалт явуулаагүй, аймгийн эрх бүхий албан тушаалтнуудын

шийдвэрээр хуулийн этгээдүүдэд техник тоног төхөөрөмжийг гэрээгээр шууд олгосон гэсэн тайлбарыг өглөө.

Бусад байгууллагууд газар тариалангийн ажил эхлэх болоогүй тул одоогоор ашиглаагүй, хуулийн этгээдийн сонгон шалгаруулалтыг хийгээгүй байна гэсэн тайлбар өгсөн.

Цаашид газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбай зэрэг хөрөнгүүдийг ТӨБЗГ-ын шийдвэрт үндэслэн орлого авдаг тул тухай бүр данс бүртгэлд тусгаагүй, хөрөнгөд бүртгэх шийдвэрийг хүлээсэн байдалтай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйл 2-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна”, Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 2 дугаар зүйлийн 2.3.1.10-д “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Дүгнэлт:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээ хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.
2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан төсөл арга хэмжээнүүд холбогдох журмын хүрээнд 0-55 хувьтай үнэлэгдсэн байна.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд дээд шатны төсөв захирагчдаас тавих хяналт хангалтгүй байна.
4. ЗГ, УИХ эрх мэдлийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад ТАХ тусгахдаа төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг харгалзан үзээгүй байна.
5. Зураг төсөлгүй, зурагт төсөлд магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан байна.
6. Төсөл арга хэмжээний батлагдсан төсөвт өртөг магадлалын дүнгээс зөрүүтэй байна.
7. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.
8. Зарим ТЕЗ нар төсөл арга хэмжээг орон нутагт эрх шилжүүлэхдээ журамд заасан хугацааг мөрдөөгүй хугацаа хоцроосон байна.
9. Захиалагч байгууллага үнэлгээний хороо байгуулагдсан байхад худалдан авах захиалгыг хүргүүлэхгүй хугацаа алдсан байна.
10. Нэг үнэлгээний хорооны гишүүд хэдэн хэдэн тендер сонгон шалгаруулалтад үнэлгээ хийсэн байна.
11. Тендерийн баримт бичгийг шаардлагын хэмжээнд боловсруулаагүй, ШӨХТГ-аас өгсөн үүрэг даалгаврын дагуу зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй, зөрчлийг давтан гаргасан байна.
12. Тендер сонгон шалгаруулалттай холбоотой гарсан гомдол маргаан өссөн байна.
13. Сангийн яамнаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.
14. Шаардлага хангасан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулаагүй, бусдад давуу байдал олгосон байх нөхцөл бүрдсэн байна.
15. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг барилга угсралтын ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.
16. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.
17. Зарим төсөл арга хэмжээний барилга угсралтын ажил эхлээгүй байна.
18. Үүрэг даалгавар өгч хүлээн авдаг зөрчил давтагдан гарсаар байна.
19. Төсөвт өртөгт зохицуулалт хийж төсөл арга хэмжээг зураг төсвийн дагуу гүйцэтгүүлээгүй байна.
20. Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбайг данс бүртгэлд тусгаагүй байна.

21. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлын үр дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгах шийдвэр тухай бүр гардаггүй байна.
22. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн зарим техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна.
23. Газар тариалан эрхлэгч хуулийн этгээдийн дунд сонгон шалгаруулалт явуулалгүй техник, тоног төхөөрөмжийг гэрээгээр олгосон байна.

Үндэсний аудитын газрын нэгтгэсэн аудитын тайланд тусгуулах санал:

1. Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-д хэдэн хувиас дээш үнэлэгдсэн төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах талаар тодорхой заалт оруулж, хязгаар тогтоох. Ингэснээр холбогдох хууль журамд заасан шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад баталдаг зөрчил буурна.
2. Дээд шатны төсөв захирагчдаас хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тавих хяналтыг сайжруулах шаардлага байна. Ингэснээр төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төсөвт тусгадаг зөрчил буурна.
3. ЗГ, УИХ эрх мэдлийнхээ хүрээнд ТАХ хэрэгжүүлэхдээ төлөвлөлтийн шаардлага хангасан байдлыг үнэлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах. Ингэснээр ТАХ-ний төсөвт өртөг зөрүүтэй батлагдах зөрчил буурах, төсөвт өртөг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага гарахгүй байхаар байна.
4. ТЕЗ-чид эрх шилжүүлэхдээ журамд заасан хугацааг мөрдөж, хугацаа хоцроохгүй байх шаардлагатай байна.
5. Худалдан авах ажиллагаатай холбоотой гаргасан гомдлын хүрээнд Сангийн яам болон бусад эрх бүхий байгууллага гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавьж байх шаардлагатай байна. Орон нутагт өгсөн шийдвэрүүдийн хэрэгжилт хангалтгүй байна.
6. Улсын комисс хүлээн авсан барилга байгууламжийг данс бүртгэлд тусгах шийдвэрийг ТӨБЗГ хүлээн авснаас хойш ямар хугацааны дотор гаргах эрх зүйн орчин шаардлагатай байна. Эсвэл данс бүртгэлд тусгах шийдвэр гаргах эрхийг орон нутагт шилжүүлэх эрх зүйн зохицуулалт хийх. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгах шийдвэр барилга байгууламжийг хүлээн авснаас хойш хамгийн багадаа 1 жилийн дараа гарч байна.
7. Төсөл арга хэмжээг комисс үүрэг даалгавар өгч хүлээн авсан нөхцөлд санхүүжилтийг бүрэн олголгүй тодорхой хувийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулдаг эрх зүйн орчныг бүрдүүлэх. Ингэснээр үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдах хөшүүрэг болно.
8. Төсвийн тухай хуульд батлагдсан төсвийг ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран орон нутагт олгож,

барьцаа хөрөнгийн дансанд байршуулан хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна. Ингэснээр шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хүйтний улиралд ажил эхлэх, дуусах асуудал буурч, барилга угсралтын ажил чанартай хийгдэх нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх аймгийн хөрөнгө оруулалтын дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулахдаа улсын хөгжлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах;
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсвийн төсөлд төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг тусгаж байх;
3. Зураг төсөлгүй, магадлалын дүнгээс зөрүүтэй төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулах захиалга хүргүүлэхгүй байх;
4. Зураг төсөв нь хийгдсэн төсөл арга хэмжээнд магадлалын дүгнэлтийг тухай бүр хийлгүүлж байх;
5. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх;
6. Төсөл арга хэмжээ бүрд үнэлгээний хороог шинээр байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.8-д заасны дагуу чиг үүргийг тодорхойлох;
7. Түдэвтэй сумын соёлын төвийн барилгын зураг төсөвт тусгагдаж, магадал хийгдсэн ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлж төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах;
8. Хөгжимт жүжгийн театр, Их уул сумын төвийн 3.0 км зам, Нөмрөг сумын Соёлын төвийн барилга зэрэг төсөл арга хэмжээнүүдийн барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх;
9. Данс бүртгэлд тусгаагүй төсөл арга хэмжээг холбогдох ашиглагч байгууллагуудад эзэмшүүлэх /Ногоон байгууламж бүхий орчны тохижилт, сумын төвийн цэвэр усны шугам сүлжээ-капиталжуулах/;
10. Хөдөө аж ахуйн чиглэлээр өгсөн техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, хоршоологчид болон газар тариалан эрхлэгч хуулийн этгээдэд түрээсээр ашиглуулах ажлыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
11. Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг түрээсээр олгох сонгон шалгаруулалт явуулалгүй шууд гэрээ байгуулсан хуулийн этгээдийн гэрээг цуцалж, сонгон шалгаруулалтыг хийж, шаардлага хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах;
12. Хилийн цэргийн 0277-р ангид олгосон техник, тоног төхөөрөмжийг сумын ЗДТГ-ын эзэмшилд шилжүүлэн, газар тариалан эрхлэгч хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллах.

Аймгийн ИТХ-ы хуралд

1. Худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээтэй иргэдийн бүртгэлийг хөтөлж, жил бүр шинэчлэн мэдээллийн сан бүрдүүлж ажиллах.


Байгууллагаас ирсэн санал, тайлбар:


**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: za@zavkhan.gov.mn

2025.09.21 № 6/372
Танай _____ Үнэ № _____ Т _____

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой саналаа хавсралтаар хүргүүлээ.
Хавсралт 2. хуудастай.

БУС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.АЗЖАРГАЛ



Doc text a5

**“УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ**

1. Тайлангийн хэсэгт Орчны тохижилт бүхий ногоон байгууламж /Завхан/, Улиастай сумын Чигэстэй багийн явган болон дугуйн зам, 3.9 км /Завхан, Улиастай сум/ гэсэн арга хэмжээнүүдийг Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн байна гэж тусгагдсан байна.
 - Тайланд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.4.1.орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт; заалтыг зөрчсөн гэсэн байна. Дээрх Орчны тохижилт бүхий ногоон байгууламж төсөл арга хэмжээг хийхдээ 7 суманд 8 сагсан бөмбөгийн талбай ногоон байгууламжийг төлөвлөж Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн хэрэгжүүлсэн.Мөн Улиастай сумын Чигэстэй багийн явган болон дугуйн зам, 3.9 км /Завхан/ гэсэн төлийн хувьд Төв тойргоос Загастайн даваа чиглэлийн Улсын чанартай авто зам дагуу явган хүн болон дугуйн зам хийгдэж байгаа нь дээрх хуулийг зөрчөөгүй гэж үзэж байгаа тул тайлангийн хэсэг болон дүгнэлт хэсгээс хасуулах саналтай байна.
2. Аудитын алдаа зөрчлийн маягт болон тайлангийн хэсэгт 71,1 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг тооцсон байна.
 - Зураг төсөлд магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан байна. /Аймгийн төсвийн төсөлд тусгасан ТАХ/
 - Цаашид ашиглах боломжгүй болж нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл арга хэмжээнүүдийг 2024 оны төсвийн төсөлд тусгаж төсөв батлагдахаас өмнө зураг төслийг бэлэн болгон хэрэгжүүлж байна. Төлөвлөлтийн шатанд зураг төсөлтэй байх талаар шаардахгүй зөвхөн хэрэгцээ шаардлага, зардал үр дүнг тооцсон байхыг шаарддаг бөгөөд төсөв батлагдах үед зураг төсөлтэй байх шаардлагатай байдаг тул энэ хэсгийг хасуулах саналтай байна.
 - Төсвийн тухай хуульд батлагдсан төсөвт өртөг нь магадлалын дүнгээс дутуу ТАХ-г хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан. Төсөвт өртөг хүрэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.
 - УИХ төсөв батлахдаа магадлалын дүнгээр төсвийг батлаагүйгээс үүдэн дээрх нөхцөл байдал үүсч байгаа тул тайлангийн хэсгээс хасуулах саналтай байна.
 - ТАХ-г гэрээний хугацаанд хэрэгжүүлэн хүлээн аваагүй байна. /ХЖТеатр, Нөмрөг сумын Соёлын төв, Их уул сумын 3км зам/
 - МУЗГ-ын 2024 оны 249 дүгээр тогтоолоор 2024 онд ашиглалтад орох боловч ашиглалтад ороогүй төсөл арга хэмжээг 2025 онд санхүүжилтийг хэрэгжүүлэхээр санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд авч гэрээ сунгагдсан тул хасуулах саналтай байна.

- Гэрээ байгуулсан зарим барилга угсралтын ажил эхлээгүй байна. / Баянхайрхан ЭМТ, Дөрвөлжин сумын Соёлын барилга, Отгон сумын хүүхдийн цэцэрлэг/
 - o Гүйцэтгэгчийн хариуцлагагүй байдлаас үүдэн Дөрвөлжин сумын соёлын төвийн барилга эхлээгүй, бусад ажлын хувьд хуулийн дагуу тендер олон удаа зарлагдаж гүйцэтгэгч хүйтний улиралд шалгаран 2025 онд ажлаа хийхээр шийдвэрлэсэн тул тайлан болон алдаа зөрчлийн нэгтгэлээс хасуулах саналтай байна.
- 3. Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Түдэвтэй сум: Төсөл арга хэмжээг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, дутуу байхад авсан гэж тайлагд дурджээ.
- Тус барилга анх 2020 онд зураг төсөлгүй 1,2 тэрбум төгрөгөөр хэрэгжихээр батлагдаж төсөвт гадна тохижилт, тайзны технологийн хэсгийн төсөв багтаагүй байна. Дахин төсөв хийлгэхэд 1,1 тэрбум төгрөгийн нэмэлт төсөв гарсан боловч 2024 оны төсөвт 548,0 сая төгрөг буюу тайзны технологийн хэсэг батлагдаж гадна тохижилтын санхүүжилт батлагдаагүй бөгөөд гүйцэтгэгч Этүгэн жим ХХК-тай 548,0 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулагдаж гэрээний дагуу ажил хийгдэн хүлээн авсан. Үлдсэн ажлыг 2026 оны төсөвт нэмэлт санхүүжилтийг батлуулж гүйцэтгэхээр ажиллаж байна. Иймд энэ хэсгийг тайлангийн хэсэг болон дүгнэлт хэсгээс хасч өгнө үү.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Ти Эс ХХК-ийн тендерт барааг нийлүүлэхэд ашиглах техникийн жагсаалт ирүүлээгүй нь шаардлагад нийцээгүй гэх гомдол үндэслэлгүй байна", "...2024.05.20-ны өдөр нийтлэгдсэн нь тендерийн нээлтээс хойш байх тул эдгээр мэдээллийг ирүүлээгүй нь шаардлагад нийцээгүй гэх гомдол үндэслэлгүй байна" гэх захиалагчийн талд гарсан шийдвэрүүд гарсан, мөн "...тодруулж нягталж үзэх нь зүйтэй байна", "...холбогдох захиалагчаас тодруулж, хянан үзэх нь зүйтэй байна" гэх шийдвэрүүд нь захиалагчийн буруу, үндэслэлгүй гэсэн утга агуулаагүй байна. Үнэлгээний хороо дахин хуралдаж "Эм И Си Ти Эс" ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр гаргасан болно.

2024 онд Худалдан авах ажиллагааны газраас зарласан доорх төсөл арга хэмжээнүүдэд Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөл /Завхан, Тосонцэнгэл сум/, Отгон сумын соёлын төвийн барилга угсралтын ажил, Улиастай сумын нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажил, Орон нутгийн хөгжлийг дэмжих шинэ хөдөө төслийн хүрээнд техник тоног төхөөрөмж худалдан авах, Богд, Чигэстэй голын төмөр бетон гүүр барих ажлуудад хийгдсэн аудитын тайлангийн дүгнэлтээр ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг цаашид хэрэгжүүлж ажиллах бөгөөд тус аудитын тайлангийн 13 дээр эрэмбэлэгдсэн асуудлаар эерэг дүгнэлт ирүүлж өгнө үү.

ДАРГА  Х.ОНОЛБААТАР



Улиастай сумын Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын тендерийн сонгон шалгаруулалтын асуудлаар.

Сангийн яам уг тендерийн оролцогч нарт өгсөн Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 7 дугаар сарын 22-ний 301,302, 303 дугаартай албан тоотуудыг хүчингүй болгосон тухай хариу ирүүлээгүй тул тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журмын 5.9-д заасан захиалагч хуулийн 28.1-д зааснаар шийдвэр дахин гаргах эсэхийг шийдвэрлэж оролцогчдод мэдэгдэнэ гэснийг үндэслэн үнэлгээний хороо дахин шийдвэр гаргасан.

Зам тээврийн сайдаас эрх шилжүүлсэн Богд, Чигэстэйн голын төмөр бетон гүүрний сонгон шалгаруулалтын асуудлаар.

Уг тендерт 2024 оны 05 сарын 21-ний өдөр нээлт хийсэн. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан тендер нь нээлт хийхэд гэрээ байгуулах хуулийн хугацаа дуусаагүй байсан тул үнэлгээний хороо Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас тодруулга авах шаардлагагүй тухайн ажлыг хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан дуусаагүй ажил гэж үзэх гэсэн дүгнэсэн. 2024 оны 07 сарын 09-ний өдөр "Тэргүүн саруул" ХХК нэхэмжлэл гаргаж захиргааны хэрэг үүсгэн шалгагдаж эхний хэлэлцүүлэг 2024 оны 08 сарын 08-ний өдөр болж шүүхээс "ЗМЗ" ХХК-тай байгуулсан гэрээг түдгэлзүүлэх хүсэлтийг хангахаас татгалзсан. Нотлох баримт цуглуулж дуусаад хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг 2024 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 10.00 цагаас явуулахаар захирамж гарсан байсан. Гэвч "Тэргүүн саруул" ХХК нь нэхэмжлэлээсээ бүхэлд нь татгалзах хүсэлтээ 2024 оны 10 сарын 28-ний өдөр гаргаж шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамж гарсан.

Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд техник тоног төхөөрөмж худалдан авах тендерийн сонгон шалгаруулалтын асуудлаар.

1. 2024.05.21 өдрийн 156 дугаартай "Бэст вүүдэн хаус" ХХК-д хүргүүлсэн албан мэдэгдэлд "Бараа нийлүүлсэн гэрээ, хүлээлгэж өгсөн актыг эх хувиас сканердан ирүүлээгүй" гэж татгалзсан, Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын найм дугаар зүйлийн 8.1, 8.1.1 дэх заалтыг хангаагүй. Мөн гэрээг эх хувиас сканердан ирүүлээгүй бөгөөд тамга, гарын үсгээ photoshop ашиглан хуулж тавиад PDF өргөтгөлөөр илгээсэн нь цаасаар үйлдээгүй, хуурамч гэрээ хийсний нотолгоо юм.

2. 03/4871 дугаартай Гомдол хянасан тухайн албан бичигт "Эм И Си Ти Эс" ХХК-ийн материалын хянан үзээд "...захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна", "...Эм И Си



**ЗАВХАН АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нутгийн удирдах ордон, 1 дүгээр баг,
Улиастай сум, Завхан аймаг, 81090
Утас: (976) 7046-2369
Цахим шуудан: zavkhanhaa@gmail.com

2025-04-18 № 159
танай -ны № т

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

**Аудитын тайлангийн төслийн
тайлбар хүргүүлэх тухай**

Завхан аймаг дахь төрийн аудитын газрын 2025 оны 04 дүгээр сарын 17 өдрийн 423 тоот албан бичгээр ирүүлсэн улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд дараах төсөл арга хэмжээнүүдийн талаар ирүүлсэн дүгнэлтэд тайлбар хүргүүлж байна. Үүнд:

Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн ажлын асуудлаар.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн, 51.7 дахь заалтад “Үнэлгээний хорооны хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ” гэж заасны дагуу үнэлгээний хороо хуралдаж ТББ–т заасны дагуу үнэлгээ хийж тус хурлын олонхийн шийдвэрээр шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн гэж үзсэн тул захиалагчид гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг хүргүүлсэн.

Отгон сумын соёлын төвийн барилга угсралтын ажлын тендер шалгаруулалтын асуудлаар.

Отгон сумын соёлын төвийн барилга угсралтын ажлын тендер шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулахад “Силикон арт дизайн” ХХК нь 2 удаа сонгон шалгаруулалтад оролцож тендер ирүүлсэн. Тус компанийн эхний сонгон шалгаруулалтад ирүүлсэн тендер нь ТББ-т заасан шалгуур үзүүлэлтүүдийн шаардлага хангахгүй байсан тул үнэлгээний хороо татгалзсан шийдвэр гаргасан. Тус компанийн 2024.07.16-ны өдөр ирүүлсэн тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу үнэлгээний хороо хянан үзэхэд “хамгийн сайн” тендер ирүүлсэн, шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн гэж үзсэн тул гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

8109000202

Улиастай сумын Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын тендерийн сонгон шалгаруулалтын асуудлаар.

Сангийн яам уг тендерийн оролцогч нарт өгсөн Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 7 дугаар сарын 22-ний 301,302, 303 дугаартай албан тоотуудыг хүчингүй болгосон тухай хариу ирүүлээгүй тул тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журмын 5.9-д заасан захиалагч хуулийн 28.1-д зааснаар шийдвэр дахин гаргах эсэхийг шийдвэрлэж оролцогчдод мэдэгдэнэ гэснийг үндэслэн үнэлгээний хороо дахин шийдвэр гаргасан.

Зам тээврийн сайдаас эрх шилжүүлсэн Богд, Чигэстэйн голын төмөр бетон гүүрний сонгон шалгаруулалтын асуудлаар.

Уг тендерт 2024 оны 05 сарын 21-ний өдөр нээлт хийсэн. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан тендер нь нээлт хийхэд гэрээ байгуулах хуулийн хугацаа дуусаагүй байсан тул үнэлгээний хороо Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас тодруулга авах шаардлагагүй тухайн ажлыг хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан дуусаагүй ажил гэж үзэх гэсэн дүгнэсэн. 2024 оны 07 сарын 09-ний өдөр "Тэргүүн саруул" ХХК нэхэмжлэл гаргаж захиргааны хэрэг үүсгэн шалгагдаж эхний хэлэлцүүлэг 2024 оны 08 сарын 08-ний өдөр болж шүүхээс "ЗМЗ" ХХК-тай байгуулсан гэрээг түдгэлзүүлэх хүсэлтийг хангахаас татгалзсан. Нотлох баримт цуглуулж дуусаад хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг 2024 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 10.00 цагаас явуулахаар захирамж гарсан байсан. Гэвч "Тэргүүн саруул" ХХК нь нэхэмжлэлээсээ бүхэлд нь татгалзах хүсэлтээ 2024 оны 10 сарын 28-ний өдөр гаргаж шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамж гарсан.

Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд техник тоног төхөөрөмж худалдан авах тендерийн сонгон шалгаруулалтын асуудлаар.

1. 2024.05.21 өдрийн 156 дугаартай "Бэст вүүдэн хаус" ХХК-д хүргүүлсэн албан мэдэгдэлд "Бараа нийлүүлсэн гэрээ, хүлээлгэж өгсөн актыг эх хувиас сканердан ирүүлээгүй" гэж татгалзсан, Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын найм дугаар зүйлийн 8.1, 8.1.1 дэх заалтыг хангаагүй. Мөн гэрээг эх хувиас сканердан ирүүлээгүй бөгөөд тамга, гарын үсгээ photoshop ашиглан хуулж тавиад PDF өргөтгөлөөр илгээсэн нь цаасаар үйлдээгүй, хуурамч гэрээ хийсний нотолгоо юм.

2. 03/4871 дугаартай Гомдол хянасан тухайн албан бичигт "Эм И Си Ти Эс" ХХК-ийн материалын хянан үзээд "...захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна", "...Эм И Си

Ти Эс ХХК-ийн тендерт барааг нийлүүлэхэд ашиглах техникийн жагсаалт ирүүлээгүй нь шаардлагад нийцээгүй гэх гомдол үндэслэлгүй байна", "...2024.05.20-ны өдөр нийтлэгдсэн нь тендерийн нээлтээс хойш байх тул эдгээр мэдээллийг ирүүлээгүй нь шаардлагад нийцээгүй гэх гомдол үндэслэлгүй байна" гэх захиалагчийн талд гарсан шийдвэрүүд гарсан, мөн "...тодруулж нягталж үзэх нь зүйтэй байна", "...холбогдох захиалагчаас тодруулж, хянан үзэх нь зүйтэй байна" гэх шийдвэрүүд нь захиалагчийн буруу, үндэслэлгүй гэсэн утга агуулаагүй байна. Үнэлгээний хороо дахин хуралдаж "Эм И Си Ти Эс" ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр гаргасан болно.

2024 онд Худалдан авах ажиллагааны газраас зарласан доорх төсөл арга хэмжээнүүдэд Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөл /Завхан, Тосонцэнгэл сум/, Отгон сумын соёлын төвийн барилга угсралтын ажил, Улиастай сумын нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажил, Орон нутгийн хөгжлийг дэмжих шинэ хөдөө төслийн хүрээнд техник тоног төхөөрөмж худалдан авах, Богд, Чигэстэй голын төмөр бетон гүүр барих ажлуудад хийгдсэн аудитын тайлангийн дүгнэлтээр ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг цаашид хэрэгжүүлж ажиллах бөгөөд тус аудитын тайлангийн 13 дээр эрэмбэлэгдсэн асуудлаар эерэг дүгнэлт ирүүлж өгнө үү.

ДАРГА  Х.ОНОЛБААТАР



Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас аудитын тайлантай холбоотой санал ирүүлээгүй байна.

Төрийн аудитын газраас шийдвэрлэсэн нь:

д/д	Ирүүлсэн санал, тайлбар	Төрийн аудитын газрын шийдвэр
Аймгийн засаг даргын санал		
1	Тайланд орчны тохижилт бүхий ногоон байгууламж /Завхан/, Улиастай сумын Чигэстэй багийн явган болон дугуйн зам, 3.9 км /Завхан, Улиастай сум/ гэсэн арга хэмжээнүүдийг Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн байна гэж тусгасан байна. Эдгээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчөөгүй гэж үзэж байгаа тул тайлан болон дүгнэлт хэсгээс хасаж өгнө үү.	Орчны тохижилт бүхий ногоон байгууламж гэсэн ТАХ нь аймгийн Засаг даргын төсвийн төсөлд тусгагдаагүй ТЭЗ-ийн шийдвэрээр хэрэгжсэн ажил тул YAГ-аар дамжуулан тусгах саналд хүргүүлэх, Улиастай сумын Чигэстэй багийн явган болон дугуйн зам, 3.9 км /Завхан, Улиастай сум/ ТАХ нь аймгийн Засаг даргын төсвийн төсөлд тусгагдсан, холбогдох журмын дагуу үнэлсэн эсэх нь тодорхойгүй тул аудитын шийдвэрийг хэвээр үлдээх.
2	Алдаа зөрчлийн бүртгэлд тусгасан дараах зөрчлүүдийг хасуулах санал ирүүлсэн. Үүнд: а/ Зураг төсөлд магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан байна. /Аймгийн засаг даргын төсвийн төсөлд тусгасан ТАХ/	Ирүүлсэн тайлбараас харахад дээд шатны төсөв захирагч нар төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаснаас уг асуудал хавтгайрсан байдлыг харуулж байна. Гэсэн хэдий ч аймгийн Засаг дарга нь төлөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-г төсвийн төсөлд тусгах нь зүйтэй гэж үзсэн тул шийдвэрийг хэвээр үлдээв.
	б/ Төсвийн тухай хуульд батлагдсан төсөвт өртөг нь магадлалын дүнгээс дутуу ТАХ-г хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан нь төсөвт өртөг хүрэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.	Ирүүлсэн тайлбараас харахад дээд шатны төсөв захирагчид болон УИХ-ын гишүүд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэж байгаа нь зөрчил гарахад нөлөөлсөн байна гэж үзлээ. Иймд YAГ-аар дамжуулан тусгах саналд тусгах
	в/ ТАХ-г гэрээний хугацаанд хэрэгжүүлэн хүлээн аваагүй байна. /ХЖТеатр, Нөмрөг сумын соёлын төв, Их уул сумын 3км зам/	ХЖТ-ын барилга угсралтын ажил нь 2024 онд бүрэн дуусах боломжтой байсан гэж үзлээ. Учир нь барилга угсралтын ажлыг хугацаа алдаж эхэлсэн байна. 2011 оноос хойш 13 жилийн турш баригдсан байна. Нөмрөг сумын Соёлын төвийн барилга нь 2019 онд эхэлсэн бөгөөд 2024 онд ажил хийгээгүй, Их уул сумын 3км авто замын ажил мөн 2019 онд эхэлсэн бөгөөд 2023 оноос хойш ямар ч ажил хийгдээгүй байна. Иймд гаргасан шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэлээ. Барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.
	г/ Гэрээ байгуулсан зарим барилга угсралтын ажил эхлээгүй байна.	Төсвийн тухай хуульд батлагдсан төсвийг буцаан татуулахгүйн тулд худалдан авах

	/Баянхайрхан эрүүл мэндийн төв, Дөрвөлжин сумын Соёлын барилга, Отгон сумын хүүхдийн цэцэрлэг/	ажиллагаагаар шаардлага хангахгүй гүйцэтгэгчийг шалгаруулж, төсвийн жил дуусахаас өмнө ямар нэгэн хуулийн этгээдтэй гэрээ байгуулж байна. Төсвийн тухай хуульд батлагдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулаагүй нөхцөлд батлагдсан төсвийг буцаан татаж байгаа нь энэхүү зөрчил гарах нөхцөлийг бүрдүүлж байна. Нэгэнт хуульд батлагдсан ТАХ-ний төсвийг буцаан татахгүй орон нутгийн барьцаа дансанд байршуулж байх эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ байгаа нь харагдаж байна. Иймд УАГ-аар дамжуулан тусгах саналд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.
3	Төсөл арга хэмжээг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, барилга угсралтын ажил дутуу байхад авсан байна гэж тайланд тусгажээ. /Соёлын төвийн барилга, 200 суудал-Завхан, Түдэвтэй/	Зураг төсөвт тусгагдсан ажлын хүрээнд бус гэрээнд тусгасан санхүүжилтийн дүнд үндэслэн хүлээн авсан тул шийдвэрийг хэвээр үлдээв.
Худалдан авах ажиллагааны газрын санал		
1	Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн ажлын асуудлаар. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн, 51.7 дахь заалтад “Үнэлгээний хорооны хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ” гэж заасны дагуу үнэлгээний хороо хуралдаж ТББ-т заасны дагуу үнэлгээ хийж тус хурлын олонхын шийдвэрээр шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн гэж үзсэн тул захиалагчид гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг хүргүүлсэн.	Тус ажлын тендерийг үнэлэхдээ үнэлгээний хорооны 3 гишүүн нь шаардлагад нийцсэн тендер ирээгүй гэж, 1 гишүүн нь өөр ХХК-ийг хамгийн сайн тендер ирүүлсэн гэж, 5 гишүүн нь ТББ-т заасан санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангаагүй, ажлын тоо хэмжээ зөрүүтэй ирүүлсэн оролцогчийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн гэж үнэлсэн учир тус саналыг хүлээн авах боломжгүй.
2	Отгон сумын соёлын төвийн барилга угсралтын ажлын тендер шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулахад “Силикон арт дизайн” ХХК нь 2 удаа сонгон шалгаруулалтад оролцож тендер ирүүлсэн. Тус компанийн эхний сонгон шалгаруулалтад ирүүлсэн тендер нь ТББ-т заасан шалгуур үзүүлэлтүүдийн шаардлага хангахгүй байсан тул үнэлгээний хороо татгалзсан шийдвэр гаргасан. Тус компанийн 2024.07.16-ны өдөр ирүүлсэн тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу үнэлгээний хороо хянан үзэхэд “хамгийн	ТББ-т заасан сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй гэрээний үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх шаардлага хангаагүй, хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллээ бүрэн гүйцэд ирүүлээгүй, хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан хоёр ба түүнээс дээш ажилтай тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно гэсэн шалгуур үзүүлэлтийг хангаагүй байхад хамгийн сайн тендер ирүүлсэн гэж үнэлсэн учир тус саналыг хүлээн авах боломжгүй.

	сайн” тендер ирүүлсэн, шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн гэж үзсэн тул гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлэхээр шийдвэрлэсэн.	
3	Улиастай сумын Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын тендерийн сонгон шалгаруулалтын асуудлаар. Сангийн яам уг тендерийн оролцогч нарт өгсөн Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 7 дугаар сарын 22-ний 301,302, 303 дугаартай албан тоотуудыг хүчингүй болгосон тухай хариу ирүүлээгүй тул тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журмын 5.9-д заасан захиалагч хуулийн 28.1-д зааснаар шийдвэр дахин гаргах эсэхийг шийдвэрлэж оролцогчдод мэдэгдэнэ гэснийг үндэслэн үнэлгээний хороо дахин шийдвэр гаргасан.	Сангийн яамнаас 2024.08.06-ны өдрийн 03/6591 дугаартай Гомдол хянасан тухай албан бичгээр “дулааны инженерийн ажилласан жилийн шаардлага хангаагүй, хөлсөөр ажиллуулах гэрээнд нөхцөлийг тодорхой тусгаагүй нь шаардлагад нийцсэн гэж үнэлсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй” гэж хянан үзэж, захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн. Тус ажлын үнэлгээний хороо 2024.08.19-ний өдөр хуралдан дахин хууль тогтоомж зөрчиж шаардлагад нийцээгүй оролцогчийг шалгаруулсан учир тус саналыг хүлээн авах боломжгүй.
4	Зам тээврийн сайдаас эрх шилжүүлсэн Богд, Чигэстэйн голын төмөр бетон гүүрний сонгон шалгаруулалтын асуудлаар. Уг тендерт 2024 оны 05 сарын 21-ний өдөр нээлт хийсэн. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан тендер нь нээлт хийхэд гэрээ байгуулах хуулийн хугацаа дуусаагүй байсан тул үнэлгээний хороо Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас тодруулга авах шаардлагагүй тухайн ажлыг хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан дуусаагүй ажил гэж үзэх гэсэн дүгнэсэн. 2024 оны 07 сарын 09-ний өдөр “Тэргүүн саруул” ХХК нэхэмжлэл гаргаж захиргааны хэрэг үүсгэн шалгагдаж эхний хэлэлцүүлэг 2024 оны 08 сарын 08- ний өдөр болж шүүхээс “ЗМЗ” ХХК-тай байгуулсан гэрээг түдгэлзүүлэх хүсэлтийг хангахаас татгалзсан. Нотлох баримт цуглуулж дуусаад хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг 2024 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 10.00 цагаас явуулахаар захирамж гарсан байсан. Гэвч “Тэргүүн саруул” ХХК нь нэхэмжлэлээсээ бүхэлд нь татгалзах хүсэлтээ 2024 оны 10 сарын 28-ний өдөр гаргаж шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамж гарсан.	Сангийн яаманд гомдол гаргаж тус яамнаас 2024.06.11-ний өдрийн 03/4914 дугаартай гомдол хянасан тухай албан бичигт “... Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас тодруулж үнэлгээ хийж Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.9-д заасныг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллана уу” гэж шийдвэрлэсэн боловч үнэлгээний хорооны 2024.06.11-ний өдрийн хурлаар гомдол хянасан албан бичигт дурдсан асуудлаар Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас тодруулж үнэлгээ хийгээгүй, үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих талаар хэлэлцээгүй учир саналыг хүлээн авах боломжгүй.
5	Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд техник тоног төхөөрөмж худалдан авах тендерийн сонгон шалгаруулалтын асуудлаар.	Сангийн яам 2024.06.10-ны өдрийн 03/4871 дугаартай Гомдол хянасан тухай албан бичгээр “.... тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна”, “... холбогдох

	1. 2024.05.21 өдрийн 156 дугаартай “Бэст вүүдэн хаус” ХХК-д хүргүүлсэн албан мэдэгдэлд “Бараа нийлүүлсэн гэрээ, хүлээлгэж өгсөн актыг эх хувиас сканердан ирүүлээгүй” гэж татгалзсан, Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын найм дугаар зүйлийн 8.1, 8.1.1 дэх заалтыг хангаагүй. Мөн гэрээг эх хувиас сканердан ирүүлээгүй бөгөөд тамга, гарын үсгээ photoshop ашиглан хуулж тавиад PDF өргөтгөлөөр илгээсэн нь цаасаар үйлдээгүй, хуурамч гэрээ хийсний нотолгоо юм. 2. 03/4871 дугаартай Гомдол хянасан тухайн албан бичигт “Эм И Си Ти Эс” ХХК-ийн материалын хянан үзээд “...захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна”, “...Эм И Си Ти Эс ХХК-ийн тендерт барааг нийлүүлэхэд ашиглах техникийн жагсаалт ирүүлээгүй нь шаардлагад нийцээгүй гэх гомдол үндэслэлгүй байна”, “...2024.05.20-ны өдөр нийтлэгдсэн нь тендерийн нээлтээс хойш байх тул эдгээр мэдээллийг ирүүлээгүй нь шаардлагад нийцээгүй гэх гомдол үндэслэлгүй байна” гэх захиалагчийн талд гарсан шийдвэрүүд гарсан, мөн “...тодруулж нягталж үзэх нь зүйтэй байна”, “...холбогдох захиалагчаас тодруулж, хянан үзэх нь зүйтэй байна” гэх шийдвэрүүд нь захиалагчийн буруу, үндэслэлгүй гэсэн утга агуулаагүй байна. Үнэлгээний хороо дахин хуралдаж “Эм И Си Ти Эс” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр гаргасан болно.	байгууллагаас нь тодруулж нягталж үзэх нь зүйтэй байна”, “...захиалагчаас тодруулж, хянан үзэх нь зүйтэй байна”, “Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье” гэж шийдвэрлэсэн байна. Үнэлгээний хороо 2024.06.24-ний өдөр хуралдаж тус тендерийг дахин хянаж үнэлэхдээ гомдол хянасан шийдвэрт заасан асуудлуудаар холбогдох байгууллагуудаас тодруулаагүй, мөн “Бэст вүүдэн хаус” ХХК-ийн тендерт ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээллийг ирүүлсэн байхад татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж Сангийн яам хянасныг харгалзалгүйгээр үнэлгээг хийсэн учир саналыг хүлээн авах боломжгүй.
6	2024 онд Худалдан авах ажиллагааны газраас зарласан доорх төсөл арга хэмжээнүүдэд Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөл /Завхан, Тосонцэнгэл сум/, Отгон сумын соёлын төвийн барилга угсралтын ажил, Улиастай сумын нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажил, Орон нутгийн хөгжлийг дэмжих шинэ хөдөө төслийн хүрээнд техник тоног төхөөрөмж худалдан авах, Богд, Чигэстэй голын төмөр бетон гүүр барих ажлуудад хийгдсэн аудитын тайлангийн дүгнэлтээр ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг цаашид хэрэгжүүлж ажиллах бөгөөд тус аудитын тайлангийн 13 дээр эрэмбэлэгдсэн асуудлаар эерэг дүгнэлт ирүүлж өгнө үү.	Саналыг хүлээн авах боломжгүй.